



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
БУЯНТ СҮМҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 8127

Шар тохой

Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага
худалдаа зарлах тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3, 33 дугаар зүйлийн 33.1.2, 36 дугаар зүйлийн 36.1 дэх заалтууд, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 3.1. дэх заалт, Барилга хот байгуулалтын сайдын 2018 оны 208 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал, сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн "2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөн нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт байршилтай БуянтОйл ШТС-ын зүүн талаас төлөвлөлтийн нэгж талбарын 2698266 дугаартай худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолборын зориулалтаар 40 жилийн хугацаатай эзэмшүүлэх 2500m² газрын дуудлага худалдааг 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсугай.

2. Дуудлага худалдааны журмаар эзэмшүүлэх 2500m² газрын анхны үнийг 2,000,000 /хоёр сая/ төгрөгөөр, дэнчингийн үнийг 200,000 /хоёр зуун мянга/ төгрөгөөр тус тус тогтоосугай.

3. Газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг захирамж гарсан өдрөөс эхлэн 30-аас доошгүй хоног олон нийтэд ил тод мэдээлэн зарлаж, дуудлага худалдааны бэлтгэл ажлыг ханган зохих журмын дагуу зохион байгуулахыг сумын Газрын даамал /Ц.Номин/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ХИБАТАЙ

